

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/22

Арвайхээр сум

**Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай
зөвшөөрөл сунгах, тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, 19.14, 19.15, 19.18, дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАЯР

622501070

My Doc.tushaal/EMG

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 18-ны
өдрийн 1/22 дугаар тушаалын
хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН НЭР

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл сунгах хугацаа	Хүчинтэй байх хугацаа/огноо
1	"Мон -Ургамал" хувийн хэвшлийн эмийн сан РД -2058871 Дугаар № ЭХ- 20/13/85	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум 5-р баг	5 жилээр	2030 оны 07 сарын 21-ны өдрийг хүртэл

---oOo---